



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

2013 ОН

Улаанбаатар хот 2014 он

Оршил

Дэлхийн 189 орны төр засгийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын Мянганы дээд хэмжээний уулзалтаар 2000 оны 9-р сард Мянганы тунхаглал бичгийг баталсан. Энэхүү баримт бичигт 2015 он хүртэлх хугацаанд шийдвэрлэвэл зохих ядуурал, эрүүл мэнд, боловсрол, хүрээлэн буй орчин хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг багцлан 8 зорилго, 18 зорилтын 48 шалгуур үзүүлттэйгээр дэвшүүлэн баталсан билээ. Дэлхийн улс орнуудын нийгэм, эдийн засгийн нийтлэг болон өвөрмөц онцлогийг харгалзан үзэх шаардлагад нийцүүлэн Мянганы хөгжлийн дээрх зорилтуудыг өргөжүүлж эдүгээ 8 зорилго 21 зорилт 60 шалгуур үзүүлэлттэйгээр баталж, 2008 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдүүлж байна.

Мянганы тунхаглалд нэгдсэн улсуудын нэгэн адил Монгол улс Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-уудаа үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан, тавьсан зорилгын хэрэгжилтийн явц байдлыг үнэлсэн тайланг тогтмол гаргаж ирсэн байна. Монгол улсын засгийн газар МХЗ-уудын анхны илтгэлээ 2004 онд гаргаж байсан бол удаах илтгэлээ 2007 гаргасан байна. Монгол улсын Их хурлаас Мянганы тунхаглал болон шинэ мянганд ядуурлыг бууруулах талаар НҮБ-аас дэвшүүлсэн зорилтыг дэмжиж, ардчилсан засаглалыг бэхжүүлэх тухай зорилгыг нэмж тусган, Монгол улсын Мянганы хөгжлийн 2015 он хүртэлх зорилтыг нийт 9 зорилго, 22 зорилт, 24 шалгуур үзүүлэлттэйгээр 2005 онд 25 дугаар тогтоолоор баталсан бөгөөд 2008 онд 13 дугаар тогтоолоор нийт 9 зорилго 24 зорилт 67 шалгуур үзүүлэлттэй байхаар шинэчлэн баталсан.

Монгол улсын хэмжээнд өнөөгийн байдлаар тооцож байгаа 64 үзүүлэлтийн 18 –ыг албан ёсны статистикийн мэдээллээс, 46-г захиргааны статистик мэдээллээс гаргаж байна.

Сонгинохайрхан дүүргийн хувьд МХЗ-уудын талаарх тоо, мэдээлэл харьцангуй цөөн байгаа учир төрийн захиргааны байгууллагад байгаа тоо мэдээлэлийг ашиглан энэхүү судалгааг хийлээ.

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ,
НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА**

Сонгинохайрхан дүүргийн онцлог

Монгол улсын Их хурлын 1992 оны 18 дугаар тогтоолын дагуу Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу зохион байгуулалтын өөрчлөлтөөр нийслэлийн Октябрь дүүргээс өрх тусгаарлан Сонгинохайрхан дүүрэг нэртэйгээр 1992 оны 10 сарын 1-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Дүүрэг анх байгуулагдахдаа засаг захиргааны 20 хороо, 24590 өрхийн 115000 хүн амтай, 9086 толгой малтай байсан бол өдгөө засаг захиргааны 32 хороо, 71747 өрхийн 277312 хүн амтай, 56107 толгой малтай нийслэлийн томоохон дүүргийн нэг болжээ.

Дүүрэг нь Монгол улсын хүн амын 9.6 хувь, Улаанбаатар хотын хүн амын 21.8 хувь, газар нутгийн 25.5 хувийг тус тус эзлэн оршиж байна. Сонгинохайрхан дүүрэг нь 1200.6 км² газар нутагтай ба нийслэлийн Баянгол, Хан-уул дүүргүүд, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Баянцогт сумдуудтай хиллэн оршдог. Дүүргийн газар нутгийн 22.0 хувь нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 19.4 хувь нь ойн сав газар, 3.6 хувь нь зам шугам байна.

Тус дүүрэг нь байгуулагдсан цагаасаа эхлэн нийслэлийн эдийн засгийн салбарт томоохон байр суурийг эзэлж ирсэн бөгөөд нийслэлийн төдийгүй Монгол улсын хэмжээнд томоохон үйлдвэрүүд болох Мах импекс ХХК, Сүү ХК, Алтан тариа ХХК, Талх чихэр ХК, Тэсо ХХК, Жэм интернэйшнил ХХК, Мах маркет ХХК түүнчлэн Сүлжээ ХК, Ган хийц ХК, Буян ХХК, Сонсголон ХК, болон тоосгоны олон үйлдвэрүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн нийслэлийн нийтийн тээвэр томоохон байр суурь эзэлдэг Цахилгаан тээвэр ХК, Сутайн буянт ХХК зэрэг тээврийн үйлчилгээ эрхэлдэг газрууд ажиллаж байна. Өнөөдөр Сонгинохайрхан дүүрэг сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн гахай, шувууны болон газар тариалангийн аж ахуйгаараа нийслэлд ихээхэн байр суурь эзэлж байна.

1998 оноос гадаад хамтын ажиллагаагаа улам бүр өргөжүүлэн БНХАУ-ын Бээжин хотын Шун И, Хөх хотын Үй Чيان дүүрэг, БНСУ-ын Бурен хот, Гуанжи хотын Гуасан, Кангдонг, Сеонбук зэрэг дүүргүүдтэй найрсаг хамтын ажиллагааны холбоо тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлын салбарт хамтран ажиллаж байна.

Гадаад орнуудтай хамтран ажиллахын зэрэгцээ нийслэлийн найман дүүрэг, болон Сүхбаатар аймгийн Асгат, Сүхбаатар сум, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум, Булган аймгийн Сайхан, Орхон сумдын засаг даргын тамгын газрын хамт олонтой хамтын ажиллагааны холбоо тогтоон, харилцан туршлага солилцон ажиллаж байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт түүх дурсгалын болон байгалийн үзэсгэлэнт газрууд, хүннүгийн булш хиргэсүүр олон байдаг. Тухайлбал: Монголын нууц товчоонд өгүүлдэг Хэрэйдийн Тоорил вангийн сууж байсан өргөөний суурь эдүгээ Сонгинохайрхан дүүргийн нутаг болох Сонгины булангийн доохно орших туурь мөн гэж эрдэмтэд баталсан байна. Хожим нь Тоорил ванг дарагдсан дараа Чингис хаан түүний Хар түнгийн ордонд өргөөлж, уг өргөөнд Чингисийн Есүй, Хулан хатад нь амьдарч байжээ. Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд 2006 онд Ван ханы тууринд дахин малтлага хийж заан,сармагчин, арслангийн шавар дүрсийг олсон байна.

Богд хаант засгийн үед Их Даншиг наадмыг тус дүүргийн нутаг болох Хүй долоон худаг гэдэг газарт хийдэг байсан бөгөөд Богд хаан бараа бологсодын хамтаар Баянхошуу уулын хярын замаар даншиг наадам үзэхээр явдаг байсан байна. Одоо энэ газарт төрийн их баяр цэнгэл наадмын хурдан морины уралдаан болдог. Тэр үед гаргасан жим одоо болтол 24 дүгээр хорооноос 21 дүгээр хорооны Гүнтийн хэсэг рүү давж ордог хэсэгт байдаг. Тэр үед Баянхошуу уулын бэлд цагаан зандан мод ургадаг байсан.

Мөн жанжин Сүхбаатарын цэргүүд 1921 онд Их хүрээг дайлаар мордохын өмнө тус дүүргийн 21 дүгээр хорооны нутагт байрлаж байсан бөгөөд дурсгалын самбар босгосон байдаг.

Эдийн засаг, нийгмийн байдал

Сонгинохайрхан дүүрэг нь Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж буй шилжилтийн эхэн үед байгуулагдсан бөгөөд энэ үед хүнсний томоохон үйлдвэрүүд ажиллаж байлаа. Улмаар үйлдвэрийн газрууд нэмэгдсэн бөгөөд 1993 онд аж үйлдвэрийн газрууд 412.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 2000 онд 15963.1 сая төгрөгийн, 2005 онд 34651.6 сая төгрөгийн 2013 онд 156161.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болсон байна. 2013 онд 2076 айлын орон сууц, 1280 хүүхдийн суудалтай ерөнхий боловсролын хоёр сургуулийг шинээр ашиглалтад оруулсан байна.

Сүүлийн жилүүдэд бодит эдийн засгийн өсөлтийг хангахын зэрэгцээ соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарыг жигд хөгжүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлснээр ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулах боломж бүрдэж эхэлжээ. 2007 онд дүүргийн хэмжээнд 6380 ажлын байр шинээр бий болж, нутаг дэвсгэрийн аж ахуй нэгж байгуулагуудад зуучлах замаар 3163 хүнийг ажил хөдөлмөрт оруулж, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1594 болж, ажилгүйдлын түвшин 1.2 хувь байсан байна. 2013 оны байдлаар бүртгэлтэй

ажилгүйчүүдийн тоо 2619 болсон ба 14696 ажлын байр шинээр бий болсон байна. Ажилгүйдлын түвшин 2.92 болсон байна.

Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 2000 онд 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо 106119 байсан ба үүний 42299 хүн буюу 39.8 хувь нь ажил эрхэлж байсан байна. 2010 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо 191206 болж 2000 оныхоос 80 гаруй хувиар нэмэгдсэн бол ажил эрхэлж буй хүний тоо 2010 онд 83943 хүн болж 2000 оныхоос 98.4 хувиар өссөн байна.

15 ба түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлт, хүйс, тооллого явагдсан оноор

Үзүүлэлт	2000			2010			2010 2000 %
	15 ба түүнээс дээш насны хүн ам бүгд	Ажил эрхэлдэг хүн амын тоо мян. Хүн	Дүнд эзлэх хувь	15 ба түүнээс дээш насны хүн ам бүгд	Ажил эрхэлдэг хүн амын тоо мян. Хүн	Дүнд эзлэх хувь	
Ажил эрхэлдэг хүн амын тоо- бүгд	106119	42299	39.8	191206	83943	43.9	198.4
Бүгдээс: Эрэгтэй	51308	21918	42.7	92088	45387	49.3	2.1 дахин
Эмэгтэй	54811	20381	37.2	99118	38556	38.9	189.2

2013 оны байдлаар 87092 ажиллагчид байгаагийн 40370 нь буюу 46.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо 85862 -т хүрсэн бөгөөд үүний 32.2 хувь нь суралцагсад, 21.5 хувь нь тэтгэвэрийн насны хүмүүс, 15.4 хувь нь хүүхдээ асарч байгаа, 4.9 хувь нь хөгжлийн бэршээлтэй иргэд байна. Эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 89710 байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, хүйсээр, оноор

Үзүүлэлт	2000	2005	2010	2011	2012	2013
Ажилгүйчүүд	1370	1500	2289	2480	2227	2619
Бүгдээс:-Эмэгтэй	688	810	1118	1153	1043	1372

Хүн амын нийслэл хот руу шилжин суурьших хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой дүүргийн хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, 2000 онд 6154 хүн шилжин ирж, 5100 хүн шилжин явж байсан бол 2013 онд 30677 хүн шилжин ирж,

26065 хүн шилжин явсан байна. Мөн сүүлийн жилүүдийн нийгмийн халамжийн үйлчилгээ, хүн амын өсөлт зэрэгтэй холбоотой төрөлтийн тоо ихэссэн бөгөөд 1998 онд 2180 хүүхэд шинээр мэндэлж байсан бол 2000 онд 2689 хүүхэд, 2006 онд 4095 хүүхэд, 2009 онд 6329 хүүхэд, 2013 онд 8176 хүүхэд шинээр мэндэлсэн байна.

Дүүргийн тоо малын тоо 2000 онд 48522 толгой мал байсан бол 2007 онд 75051 толгой мал болж 7.7 хувиар өсч байсан бол 2013 онд 56107 толгой мал болж 2007 оныхоос 25.2 хувиар буурсан байна. Учир нь нийслэл хотын оршин суугчдын эрүүл, аюулгүй байдлыг хангахын тулд нийслэл хотод мал, тэжээвэр амьтдын суурьшуулахгүй байх шийдвэрийн дагуу мал, тэжээвэр амьтад бүхий иргэд хотоос зайдуу суурьших болсонтой холбоотой малын тоо буурч байна. Иргэд малаас гарч байгаа ашиг шимийг нэмэгдүүлэхийн тулд эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх сонирхолтой болохын зэрэгцээ гахай, тахианы аж ахуйг ихээхэн хөгжүүлж байна. 1998 онд 310 гахай, 11285 шувуутай байсан бол 2007 онд 4483 гахай, 23310 шувуу, 2013 онд 8681 гахай, 15434 шувуу болсон байна. Гахайн тоо 1998 оныхоос 28 дахин, шувууны тоо 36.7 хувиар өссөн бол 2007 оныхоос гахай 93.6 хувиар өсч шувууны тоо 33.7 хувиар буурсан байна.

Сүүлийн жилүүдэд газар тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж нэмэгдэж үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалт нэмэгдэх хандлагатай болсон байна. Жишээлбэл: 2001 онд 294.5 га газарт тариалалт хийж байсан бол 2006 онд 420.6 га болж өссөн байна. 2013 онд 689.5 га болж, 2006 оныхоос 63.9 хувиар өссөн байна.

Малын тоо, төрлөөр

Он	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2000	48522		3576	11072	21490	13384
2005	58286	1	2243	15295	20622	20125
2010	56037	3	4507	18137	17824	15566
2013	56107		5888	19167	17580	13472

Тэжээвэр амьтдын тоо, зарим оноор

Үзүүлэлт	1998	2000	2005	2010	2013
Гахайны тоо	310	447	3847	3682	8681
Шувууны тоо	11285	11829	2823	22032	15434

Сүүлийн жилүүдэд иргэдийн амьжиргаа дээшилж байгаа бөгөөд дүүргийн авто машины тоо 2013 онд 45198 болсон байна. Энэ нь нийслэлийн нийт автомашины 17.6 хувь болж байна.

Тариалсан талбай, га-гаар

Үзүүлэлт	2000	2004	2005	2010	2012	2013
Нийт тариалсан талбай	521	308.8	225.2	556.5	802.3	689.5
Бүгдээс: Төмс	189	176.4	156.5	281.2	410.5	252.1
Хүнсний ногоо	332	132.4	68.7	115.3	191.8	101.3

Дүүргийн хүн ам өсөн нэмэгдэхийн хирээр тэдэнд үзүүлж байгаа нийгмийн халамжийн үйлчилгээ мөн л өсөн нэмэгдэж байна. 2005 онд нийгмийн даатгалын сангаас 13169 өндөр настанд 6421.0 сая төгрөгийн тэтгэвэр олгож байсан бол 2013 онд 17262 өндөр настанд 53715.9 сая төгрөгийн тэтгэвэр олгосон байна.

Мөн нийгмийн халамжийн сангаас 2001 онд 4770 хүнд 360.9 сая төгрөгийн тэтгэмж, тусламж үзүүлж байсан бол 2006 онд 99842 хүнд 16231.3 сая төгрөгийн, 2010 онд 267267 хүнд 30158.8 сая төгрөгийн, 2011 онд 283785 хүнд 72147.3 сая төгрөгийн, 2013 онд 55939 хүнд 19415.0 сая төгрөгийн тэтгэмж, туслалцааг үзүүлсэн байна.

Дүүргийн хүн амын тоо нэмэгдэхийн хирээр сургууль, цэцэрлэгийн хэрэгцээ нэмэгдсэн бөгөөд 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 2-5 настай хүүхдийн тоо 10387 хүүхэд байсан бол 2010 оны тооллогын дүнгээр 19216 хүүхэд болж 85.0 хувиар өссөн байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хүмүүжигчдын тоо 1993 оны байдлаар сургуулийн өмнөх боловсролын 30 байгууллагад 4466 хүүхэд суралцаж байсан бол 2000 онд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоо нэмэгдээгүй мөртлөө суралцагч хүүхдийн тоо 6130 болж 37.2 хувиар өссөн байна. 2004 оноос сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоо нэмэгдэж, 2004 онд 36 болж түүнд 6713 хүүхэд суралцаж байсан байна. 2010 оны байдлаар сургуулийн өмнөх боловсролын 50 байгууллагад 10561 хүүхэд суралцаж байсан бол 2013 онд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоо 75 болж 15746 хүүхэд суралцаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хувьд 1993 онд 17 сургуульд 21130 хүүхэд суралцаж байсан бол 1998 онд цогцолбор сургуулиуд болж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 11 сургууль болсон боловч суралцагчдын тоо 24985 болсон байна. 2004 онд ерөнхий боловсролын 20 сургуульд 33253 хүүхэд суралцаж байсан бол 2013 онд ерөнхий боловсролын 24 сургуульд 37211 хүүхэд суралцаж байна.

МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЗОРИЛГО 1. ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ ЗОРИЛТ

Зорилт 1. Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1996 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах

Зорилт 2. Хоол, тэжээлийн дутагдалтай хүн амын тоог 2003 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулна.

Зорилт 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж буй залуучуудын ажилгүйдлын түвшинг бууруулах

Зорилт 4. Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах

Ядуурлын түвшин Сонгинохайрхан дүүрэгт 1993 оны байдлаар 2666 өрхийн 13528 хүн ядуу амьдарч байсан байна. 1997 онд 5981 өрхийн 29114 хүн, 2000 онд 13151 өрхийн 60523 хүн ядуу амьдардаг гэсэн үзүүлэлт байна. Энэ тоо 2001 онд 13652 өрхийн 60970 хүн болж өссөн байна. \2002 он хүртэл дүүргийн хэмжээнд ядуу өрх, хүн ам гэсэн үзүүлэлтийг тооцож байсан\ 2006 оны байдлаар нийт 48020 өрхийн 210.6 мянган хүн ам амьдарч байснаас 35.9 хувь нь амьжиргааны түвшинээс доогуур орлоготой байсан байна. Сүүлийн жилүүдэд төр засгаас ядуурлыг бууруулах, нийгмийн хамгаалалыг сайжруулах талаар өргөн хүрээтэй арга хэмжээ жилээс жилд авч байгаа боловч хүн амын нийслэлд шилжин суурьших хөдөлгөөн энэ чиглэлд зарцуулж байгаа хөрөнгийн хэмжээ зэрэг нь ядуурлыг бууруулахад дорвитой нөлөөлөхгүй байна. Мэдээллээс үзэхэд өрх толгойлсон эмэгтэй, олон хүүхэдтэй, ажилгүй иргэд, боловсролын түвшин доогуур, нийгмийн идэвхи муутай иргэд, өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, харж хандах хүнгүй хүүхдүүд, залуу гэр бүл ядууралд илүү өртөмтгий байна.

Ядуурлын түвшин, харьцуулсан оноор

Үзүүлэлт	1995	2002	2006	2010	2013
Улсын дундаж	36.3	36.1	32.2	38.7	27.4
Сонгинохайрхан дүүрэг	21.3 (1996)	53.3	35.9	-	-

*Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ, Монгол улсын статистикийн эмхэтгэл 2007,2013
СХД-ийн статистикийн хэлтэс*

Ядуурал үүсгэж буй үндсэн шалтгааныг тодруулбал, ажилгүйдэл, гэр бүл салалт, залуучуудын ажил эрхлэх сонирхол бага, мэргэжлийн ур чадвар сул, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд бичиг баримтын зөрчилтэйгээс нийгмийн суурь үйлчилгээ авч чадахгүй байх, өрхөд байгаа хөдөлмөрийн чадваргүй, байнгын асаргаа, халамж шаардлагатай хүмүүсийн өрхийн амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж байна. Ядуурлыг бий болгож байгаа бас нэг шалтгаан нь ажлын байрны хомсдол, цалин хөлс бага, хүн амын бэлэнчлэх сэтгэлгээнээс хамааралтай байна гэж үзэж байна.

Хоол тэжээлийн дутагдал Зах зээлд шилжсэнээс хойш хэсэг хугацаанд эдийн засгийн өсөлт саарч өрхийн амьжиргааны түвшин доройтсоноос хүүхдүүд хоол тэжээлийн дутагдалд орох болсон. Эмзэг бүлгийн гэр бүлд төрсөн хүүхэд бага жинтэй хэвийн төрсөн хүүхэдтэй харьцуулахад тураалд 4 дахин илүү өртөж байна.

Эцэг эхийн үр хүүхэддээ тавих анхаарал суларсан, иргэд хэрэглэж байгаа хоол, хүнснээсээ зайлшгүй шаардлагатай амин дэмээ дутуу авч, ялангуяа амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн, олон хүүхэдтэй өрхүүд хүүхдүүддээ хангалттай хоол, амин дэм өгч чадахгүй байгаагаас тураалтай, өсөлтийн хоцрогдолтой, туранхай хүүхдүүд бий болж байна.

Тодорхой оршин суух хаяггүй болон бүртгэлгүй өрхийн хүүхдүүд эрүүл мэндийн байгууллагаас жилд 2 удаа үнэ төлбөргүй өгдөг А, Д амин дэмийг хүртэж чадахгүй хоцорч байна. Хүүхдэд шаардлагатай А, Д амин дэм, төмрийн бэлдмэл, иод дутсанаас хүүхэд өсөлтийн хоцролд өртөж байна.

Хоол, тэжээлийн дутагдалтай хүүхдийн тоо, хувиар

Үзүүлэлт	1993	2003	2005	2010	2013
5 хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь					
Улсын дундаж	12.0 (1992)	12.7 (2000)	6.3	4.7	-
Сонгинохайрхан дүүрэг	6.42	1.03	1.14	0.79	0.26
5 хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь					
Улсын дундаж		25.0	21.0	15.9	-
Сонгинохайрхан дүүрэг	1.25	1.98	1.86	0.66	0.25
5 хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх хувь					
Улсын дундаж	-	-	-	2.3	-
Сонгинохайрхан дүүрэг	8.69	2.92	2.52	1.11	1.07

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ, Монгол улсын статистикийн эмхэтгэл 2007,2013
СХД-ийн Эрүүл мэндийн нэгдэл

Хүүхдэд төмөр дутагдсанаас Н дутлын цус багадалт үүсч өвчинд өртөмхий болж оюуны болон бие бялдарын хөгжил хоцорч байна.

5 хүртэлх настай хүүхдийн өсөлтийн үзүүлэлт

Он	1-5 настай хүүхдийн тоо	5 хүртэлх насны тураалтай хүүхдийн тоо	5 хүртэлх насны өсөлтийн хоцрогдолтой хүүхдийн тоо	5 хүртэлх насны туранхай хүүхдийн тоо	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлийн түвшин
1993	5762	370	72	501	
1995	6386	155	68	480	44
2000	8573	149	55	450	32
2005	15775	122	61	389	11
2010	20791	165	138	231	25
2013	24628	65	63	265	15

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин Сонгинохайрхан дүүргийн хүн амын тоо 1993 онд 115000 байгаагаас хөдөлмөрийн насны хүн ам 56.1 хувийг эзэлж байсан байна. 2000 онд хөдөлмөрийн насны хүн амын тоо 51058 буюу нийт хүн амын 20.2 хувь болсон бол 2013 оны байдлаар энэ тоо 90015 болж, нийт хүн амын 32.4 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам байна. 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 15 ба түүнээс дээш насны ажил эрхэлдэггүй хүн амын 5.5 хувь нь хөдөлмөрийн чадваргүй хүн ам байсан бол 2010 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 5.9 хувь байна.

Хүн амын ажил эрхлэлт

Үзүүлэлт	1994	2004	2007	2010	2013
Суурин хүн амын тоо	118097	195721	220295	252265	277312
Хөдөлмөрийн насны хүн амын тоо	64461	122234	141606	191206	181877
Эдийн засгийн идэвхитэй хүн ам	44251	80577	81671	101191	89709
Ажиллагсад	42517	79206	80077	83943	87090
Бүртгэлтэй ажилгүй	1734	1371	1594	2289	2619
Ажиллах хүчний оролцооны түвшин					
Улсын дундаж	-	-	64.2	61.6	61.9
Сонгинохайрхан дүүрэг	68.6	65.9	57.7	52.9	49.3
15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин					
Улсын дундаж	-	3.6	3.2	19.5	16.6
Сонгинохайрхан дүүрэг	-	0.89	1.02	1.33	0.26

Сонгинохайрхан дүүргийн хүн амын тоо 1994 онд 118097 хүн ам байсан бол 2007 онд 220295 хүн амтай болж 86.5 хувиар, 2013 онд 2007 оныхоос 25.9 хувиар тус тус өссөн байна. Хөдөлмөрийн насны хүн амын тоо 1994 онд 64461 байсан бол 2007 онд 141606 хүн болж 2.1 дахин өссөн бол 2013 онд 181877 болж 28.4 хувиар өссөн нэмэгдсэн байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 1994 онд 68.6 хувь байсан бол 2007 онд 57.7 хувь, 2013 онд 49.3 хувь болж буурах хандлагатай байна. Дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн амын тоо 2005 онд 27069 хүн байснаа 2008 онд 26884 хүн болж өссөн нэмэгдсэн ба 2013 онд хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн ам 3739 болсон байна. Энэ нь 2009 оноос эхлэн хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг ҮСХ-ны Ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцож гаргадаг болсонтой холбоотой. Хөдөлмөр эрхлээгүй хүн амын

доторх хөдөлмөрийн чадваргүй хүн амын тоо 2005 онд 6313 хүн, 2008 онд 3098 хүн байсан бол 2013 онд 4239 хүн болжээ. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдлыг харахад хөдөлмөр эрхлээгүй хүн амын насны бүтэц ихээхэн залуужиж байгаа бөгөөд ажиллах хүчний эгнээнд шинээр орогсад ажилгүйдэлд илүү өртөж байна. Мөн хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд ажилгүйдэлд ихээр өртөж, үүний зэрэгцээ албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийн мэдээлэл хомс байна. Ажиллах хүчний мэргэжлийн түвшин доогуур, өрсөлдөх үр чадвар бага, сахилга хариуцлагын түвшин доогуур байгаа нь зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажлын байрны шаардлагыг хангахгүй, шинээр бий болсон ажлын байр нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөн Сонгинохайрхан дүүргийн хүн амын механик өсөлт жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Хөдөө орон нутгаас шилжин ирэгсэдээс гадна сүүлийн жилүүдийн газар өмчлөл, олголттой холбоотойгоор тус дүүрэгт суурьших иргэдийн тоо өссөөр байна. Дүүргийн хэмжээнд 2004 онд 15198 хүн, 2007 онд 7142 хүн 2013 онд 30677 хүн шилжин иржээ. Шинээр суурьшигчидтай холбоотойгоор сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн үйлчилгээний хүрэлцээ, цахилгаан эрчим хүчний хангамж, ундны усны хангамж, ажлын байрны хүрэлцээ гээд хүндрэлтэй асуудлууд улам бүр нэмэгдэж байна.

Хөдөө орон нутгаас шилжин ирэгсэдийн дийлэнх хэсэг нь санхүүгийн эх үүсвэр багатай, иргэдийн боловсролын түвшин доогуур, мэргэжилгүй, бичиг баримтын зөрчилтэй зэрэг асуудлууд түгээмэл байдаг үүнтэй уялдаатайгаар дүүргийн удирдлагуудын зүгээс иргэдийн бичиг баримтжуулах, ажлын байртай болгох, мэргэжил боловсролтой болгох талаар байнга анхаар ажиллаж байна. Дүүргийн бүртгэлийн хэлтэс жил бүр бичиг баримтын зөрчилтэй иргэдийн бичиг баримтжуулах ажлын зохион байгуулж ирсэн бөгөөд төрийн байгууллага болон төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр 2014 онд 95 иргэнийг бичиг баримттай болгосон байна. Түүнчлэн албан бус боловсролын Гэгээрэл төв, хөдөлмөрийн хэлтэс болон Дэлхийн зөн олон улсын байгууллага зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд иргэдэд боловсрол, мэргэжил олгох ажлыг тогтмол зохион байгуулан явуулж байна. 2013 онд Хөдөлмөрийн хэлтэс 3855 иргэнийг ажилд зуучлан оруулж, 730 хүнийг мэргэжил олгох сургалтанд хамруулсан байна. Албан бус боловсролын Гэгээрэл хөгжил төв 2010 онд 18 хүүхдэд, 2013 онд 5 хүүхдэд суурь болон бүрэн дунд боловсрол олгосон байна.

Шилжин ирэгсэд нь ихэвчлэн ажил эрхлэх, зах зээлд ойртох, амьдралын нөхцөл байдлаа сайжруулах, чанартай эмнэлэгийн үйлчилгээ авах, үр хүүхдийнхээ ирээдүйг бодон төрөл саднаа бараадах, суралцах гэсэн шалтгааны улмаас шилжилт хөдөлгөөнд оролцдог байна.



ЗОРИЛГО 2. БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ

Зорилт 5. 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох

ЗОРИЛГО 3. ЖЭНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

Зорилт 6. 2009 он гэхэд бага дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой харьцааг хангах

Зорилт 7. Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жэндэрийн тэгш байдлыг хангах

Зорилт 8. Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Бага боловсрол Сонгинохайрхан дүүргийн бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 2000 онд 95.1 хувь байсан бол 2007 онд 91.3 хувь, 2013 онд 85.6 хувь болсон байна. Сонгинохайрхан дүүргийн хувьд хүн амын тоо өсөн нэмэгдэхийн хирээр сургуулийн хүртээмж муудаж, ачааллаа даахгүй болсны зэрэгцээ амьдралын боломж муутай иргэд хүүхдээ сургууль завсардуулах явдал их байгаатай холбоотойгоор хамран сургалтын цэвэр жин буурч байна. Гэхдээ нэгдүгээр ангид элсэн ороод тавдугаар анги хүртэл суралцагсадын хувь 2000 онд 85.7 байснаа 2007 онд 89.2 хувь, 2013 онд 91.1 хувь болж өссөн байна.

Бага боловсрол, бичиг үсэгт тайлагдалт

Үзүүлэлт	1997	2000	2007	2013
Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин				
Улсын дундаж	97.5	95.0	92.7	96.0
Сонгинохайрхан дүүрэг	95.3	95.1	91.3	85.6
Нэгдүгээр ангид элсэн ороод тавдугаар анги хүртэл суралцагсадын хувь				
Улсын дундаж	81.3 (1998)	83.6	89.9	94.0
Сонгинохайрхан дүүрэг	90.3	85.7	89.2	91.1
15-24 насны залуучуудын бичиг үсгийн тайлагдалтын хувь				
Улсын дундаж	99.0 (1992)	97.7	98.5 (2010)	-
Сонгинохайрхан дүүрэг	-	99.5	(2010)	-

*Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ, Монгол улсын статистикийн эмхэтгэл 2007,2013
СХД-ийн Боловсролын хэлтэс*

1993 оны байдлаар дүүргийн хэмжээнд ерөнхий боловсролын 17 сургуульд 21130 хүүхэд суралцаж, нийт 866 багш ажиллаж байсан байна. 2000 онд 14 сургуульд 29144 хүүхэд суралцаж, 1059 багш ажиллаж байсан бол 2013 онд төрийн болон хувийн өмчийн 24 сургуульд 37211 хүүхэд суралцаж, 1686 багш ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт 2006 онд 720 хүүхдийн сургууль, 2007 онд 640 хүүхдийн сургууль, 2012 онд 640 хүүхдийн сургууль, 2013 онд 1280 хүүхдийн сургууль шинээр ашиглалтад орсон боловч улам бүр өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээгээ хангаж чадахгүй, сургуулийн суудлын тоо хүрэлцэхгүй, анги дүүргэлтийн тоо тогтоосон хэмжээнээс давсан хэвээр байна.

Суралцагсадын хүйсийн харилцаа 2013 оны байдлаар дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 1-5 ангид нийт 19398 хүүхэд суралцаж байна. Сонгинохайрхан дүүрэгт бага боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн харьцаа 2000 онд 1.08 байсан бол 2007 онд 1.01, 2013 онд 0.97 болсон байна. Эндээс

харахад бага боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн харьцаа бараг тэнцүү байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хувьд хүйсийн харьцаа 2000 онд 1.23, 2007 онд 1.17 байсан бол 2013 онд 0.97 болсон байна. Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс шалтгаалан ядуурал, ажилгүйдэл нэмэгдэн сургууль завсардах явдал ихсэж байна. Ялангуяа сургуулийн насны эрэгтэй хүүхдүүд өрх гэрийнхээ амьдралд туслах зорилгоор ажил хийх явдал байна. Хөдөө орон нутгаас шилжин ирэгсэдийн дунд бичиг баримтын зөрчлийн улмаас сургууль хүүхдээ оруулж чадахгүй байх нөгөө талаас сургуулийн тоо, хүчин чадлын хүрэлцээ муугаас шалтгаалан хамран сургах тойргийн сургуульд суралцахгүй байх, сургуулийн насны олон хүүхэдтэй өрхүүд эмэгтэй хүүхдээ түлхүү сургах болсон нь ерөнхий боловсролын сургуульд суралцагсадын хүйсийн ялгааг ихэсгэж байна.

Охид, хөвгүүдийн харьцаа, боловсролын түвшингээр

Үзүүлэлт	2000	2007	2010	2013
Бага боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн харьцаа				
Улсын дундаж	1.01	0.97	0.96	0.96
Сонгинохайрхан дүүрэг	1.08	1.01	0.94	0.95
Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн харьцаа				
Улсын дундаж	1.20	1.08	1.07	1.05
Сонгинохайрхан дүүрэг	1.23	1.17	1.03	0.97
Дээд боловсрол эзэмшиж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдийн харьцаа				
Улсын дундаж	1.72	1.54	1.48	1.41
Сонгинохайрхан дүүрэг	1.18	1.38	1.30	1.25

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ, Монгол улсын статистикийн эмхэтгэл 2007,2013

СХД-ийн Боловсролын хэлтэс

Эрэгтэй хүүхдүүд ажил хийгээд айл гэрээ аваад явчих боломжтой, харин эмэгтэй хүүхдүүд боловсрол эзэмших нь дээр гэсэн үзэл бодол нь дээд сургуульд суралцагсадын хүйсийн харьцаанд ихээхэн нөлөөлж байна. Гэхдээ сүүлийн жилүүдэд эцэг эхчүүд боловсролын үнэ цэнийг ойлгон зохих шатны боловсрол олгох эрмэлзлэлтэй болсонтой холбоотойгоор сургууль завсардах явдал буурах хандлагатай болж байна.

Цалинтай ажил эрхлэгчдийн хүйсийн харьцаа Сонгинохайрхан дүүрэг нь 2007 оны байдлаар 220.3 мянган хүн амтайгаас 51.6 хувь нь буюу 113.6 мянган хөдөлмөрийн насны хүн ам байна. Үүний 76.5 мянган нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд эдийн засгийн идэвхитэй хүн амын 52.5 хувь, ажиллагсадын 52.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Дүүргийн дүнгээр 2013 оны байдлаар 181.9 мянган хөдөлмөрийн насны хүн ам байгаагаас 53.1 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд эдийн

засгийн идэвхитэй хүн амын 46.3 хувь нь эмэгтэйчүүд байна. 2013 оны байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн 52.4 хувь нь эмэгтэй байна.

Дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо, хувиар

Үзүүлэлт	1996	2000	2004	2008	2012
Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчөөр сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	34.3	34.3	34.3	25.7	46.3
Хороодын засаг дарга нарт эмэгтэй дарга нарын эзлэх хувь	-	44.1	64.1	56.0	65.6

Мэдээллийн эх үүсвэр: Статистикийн хэлтэс

Улс төрч эмэгтэйчүүдээс дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд төлөөлөгчөөр сонгогдсон эмэгтэйчүүд 1996-2000 оны сонгуулийн жилд 28.5 хувь, 2000-2004 онд 34.3 хувь, 2004-2008 онд 37.1 хувь байсан бол 2012-2016 оны сонгуулийн жилд 46.3 болж нэмэгдсэн байна.

Сонгинохайрхан дүүрэг нь 1993 онд засаг захиргааны анхан шатны нэгж болох 20 хороотой үйл ажиллагаагаа эхэлж байсан бол 2008 оноос 25 хороо болж өргөжсөн ба 2012 оноос 32 хороогоор төрийн үйлчилгээг үзүүлж байна. Хороодын засаг нарын хувьд 2000-2004 онд эмэгтэйчүүд 44.1 хувь байсан бол 2004-2008 онд 64.1 хувь, 2012-2016 онд 65.6 хувь болж нэмэгдсэн байна.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс илүү өндөр түвшинд боловсрол эзэмшиж байгаа боловч шийдвэр гаргах дээд түвшинд харьцангуй цөөхөн эмэгтэйчүүд ажиллаж байгаа ба дунд доод түвшиний удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн оролцоо их байдаг.



ЗОРИЛГО 4 ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ

Зорилт 9. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2005 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах

ЗОРИЛГО 5 ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ

Зорилт 10. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдэлийг 2000 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах

Хүүхдийн эндэгдэл Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн дийлэнх нь амьдралынх нь эхний жилд тохиолдож байгаа бөгөөд энэ нь эхийн хоол, тэжээлийн дутмаг, хүүхдийн өсөлт, хөгжилд тавих эцэг эхчүүдийн анхаарал халамж, мэдлэг хангалтгүй, гэр бүлийн таагүй орчин эмчийн хяналтанд эрт ороогүй зэргээс шалтгаалдаг байна. Ялангуяа нийгмийн эмзэг хэсгийн жирэмсэн эхчүүдийн эрүүл мэнд болон гадны нөлөөлөлөөс шалтгаалсан дутуу төрөлт, бага жинтэй, тураалтай хүүхдүүд илүү эндэж байна. 0-1 насны хүүхдийн эндэгдэлд хийсэн судалгаанаас харахад нярайн 60-70 хувь нь төрсний дараах долоо хоногт эндэж байгаа нь ургийн хөгжлийн гажигийг жирэмсний эрт үед оношилж чадаагүйгээс амьдрах чадвар муутай хүүхэд оноор төрж байгаатай холбоотой гэсэн дүгнэлт гарсан байна. Дүүргийн хэмжээнд нялхасын эндэгдэлийн түвшин 2003 оны байдлаар 16 байсан ба 2007 онд 10 болж буурч байснаа , 2013 онд 14 болж өссөн байна.

Дүүргийн хэмжээнд тураалтай, туранхай хүүхдийн эзлэх хувь өндөр байгаа нь 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг нэмэгдүүлж байна. Энэ нь хүүхдийн асаргаа муу, буруу хооллолт, эхийн хоолны чанар хангалтгүй, тэжээллэг хүнсний хэрэглээ дутмаг зэрэг олон зүйлээс шалтгаалж байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлийн түвшин 2005 онд 3 онд байсан бол 2010 онд 4 болсон бол 2013 онд 3 болсон байна.

Хүүхдийн эндэгдэл

Үзүүлэлт	2000	2007	2010	2013
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин				
Улсын дундаж	45	22	26	18
Сонгинохайрхан дүүрэг	-	3	4	2
Нялхасын эндэгдэлийн түвшин				
Улсын дундаж	33	21	20	15
Сонгинохайрхан дүүрэг	16 (2003)	10	14	14
Улаан бурхны эсрэг вакцинжуулалтад хамрагдсан хүүхдийн хувь				
Улсын дундаж	92.4	98.4	96.9	97.0
Сонгинохайрхан дүүрэг	99.83	99.48	99.6	100.0

*Мэдээллийн эх үүсвэр: ҮСХороо, Статистикийн эмхэтгэл
СХД-ийн Эрүүл мэндийн нэгдэл*

Дүүргийн хэмжээнд 2007 оны байдлаар улаан бурханы эсрэг вакцинд хамрагдалт 99.48 хувь байсан бол 2013 оны байдлаар 100 хувьд хүрсэн байна. Улаан бурханы эсрэг вакцинжуулалтад бүрэн хамрагдсанаас энэ өвчин зогссон байна.

Нялхасын эндэгдэл хэдийгээр буурсан боловч тэтгэмж, халамжинд хамрагдах сонирхолтой ажилгүй, эмзэг бүлгийн эхчүүдийн жирэмслэлт нэмэгдэж, амьдралын

боломж муутай, эрүүл мэндийн мэдлэг хангалтгүй эцэг эхчүүдийн хүүхдийн өвчлөл их, суурь өвчнөөс шалтгаалсан нас баралт их байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд Монгол улсын Засгийн газар НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Нөхөн үржихүйн гурван үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Үүний үр дүнд гэр бүл төлөвлөлтийг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний салшгүй нэгэн хэсэг болгон хөгжүүлж, үр дүнд нь хүн амын тодорхой хэсэг жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргуудыг хэрэглэн, төрөлт хоорондын зайг зохистой түвшинд хадгалан, хүсээгүй болон төлөвлөгөөгүй жирэмслэлтийн улмаас эх хүүхдэд учрах эрүүл мэндийн эрсдлээ бууруулж чаддаг болсон хэмээн дүгнэж байна. НҮБ-ын ХАС-ийн 2011 оны статистик мэдээллээр нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тал хувь нь жирэмснээс сэргийлэх орчин үеийн аргыг хэрэглэдэг гэсэн тооцоо гарсан байна. Дүүргийн хэмжээнд эхийн эндэгдэлийн түвшин 2000 онд 116 байсан бол 2005 онд 112, 2007 онд 104, 2013 онд 38 болж буурсан байна. Хэдийгээр тоон үзүүлэлт буурч байгаа ч эхийн эндэгдэл тасрахгүй байна. Дүүргийн хэмжээнд төрөх эмнэлэг байдаггүй бөгөөд жирэмсэн эхчүүдийг өрхийн эмнэлэгийн хяналтанд байлган, төрөх үедээ нийслэлийн төрөх эмнэлэг рүү шилжүүлэн төрүүлж байна. Жирэмсэн эхчүүдэд зориулсан тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлэгүүдэд тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу, өрхийн эмнэлэгийн ачаалал их, эмнэлэгийн ажилтнуудын ур чадвар дутагдах зэрэг бэрхшээлүүд тулгарч байна. Нийгмийн эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн амьжиргааны нөхцөлөөс шалтгаалан эмнэлэгийн үзлэг, хяналтад хамрагддаггүйгээс эхийн эндэгдэл гарч байна.

Эхийн эндэгдэлийн түвшин

Үзүүлэлт	2000	2007	2010	2013
Улсын дундаж	166	88	47	43
Сонгинохайрхан дүүрэг	116	104	00	38

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХороо, Статистикийн эмхэтгэл

СХД-ийн Эрүүл мэндийн нэгдэл

Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулахын төлөө дүүргийн эрүүл мэндийн байгууллагууд ажиллаж байгаа ч иргэдийн өөрсдийн оролцоо муу, эрүүл мэндээ анхаардаггүй зэрэг нь эх хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн эрхтэн тогтолцооны эмгэгтэй жирэмсэн эхчүүд олон байна. Цус багадалт, зүрх судас, элэг, бөөр, жирэмсний хожуу үеийн гэх мэт эмгэгтэй холбоотойгоор эхийн эндэгдэл гарсаар байна.

Үр хүүхэд төрүүлж, өсгөн, удам залгах нь хүмүүн төрөлхтний заяамал эрх бөгөөд энэхүү эрхээ хангахад нь тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх үүргийг төр хүлээх ёстой.



ЗОРИЛГО 6 БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУС\ХДХВ\, ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛЫН \ДОХ\, СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ

Зорилт 11. 2015 он гэхэд хүний дархлал хомсдолын вирус \ХДХВ\, дархлалын олдмол хомсдол \ДОХ\ өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх

Зорилт 12. 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах

Зорилт 13. Хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах

ХДХВ-ын халдвар Хүний дархлал хомсдолын вирус /ХДХВ/-ийн халдвар нь ХДХВ-ээр үүсгэгддэг архаг явцтай халдвар юм. Дархлалын тогтолцоог гэмтээх явц нь 6 сараас 10 жил үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд тухайн хүнд зовиур илрэхгүй ч халдвараа тараах эрсдэлтэй байдаг. ХДХВ-ийн халдвартай эхээс хүүхдэд: жирэмсэн үед, төрөх үед болон төрсний дараа хөхний сүүгээр дамжин халдварлах магадлалтай байдаг байна. Иймээс жирэмсэн эмэгтэйчүүд жирэмсэн байх хугацаандаа 1-2 удаа ХДХВ-ын үзлэгт хамрагдсан байх ёстой байдаг. Шинжилгээнд байнгын оршин суугч жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдаж байгаа боловч бүртгэлийн болон бичиг баримтын зөрчилтэй эхчүүд хяналт, шинжилгээнд хамрагдаж чадахгүй байна.

Жирэмсэн эхчүүдийн ХДХВ-ийн шинжилгээнд хамрагдсан байдал

Үзүүлэлт	1993	2000	2004	2007	2010	2013
16-49 насны эмэгтэйчүүдийн тоо	28401	38900	59941	65982	75477	82153
Жирэмсэн эхийн ХДХВ-ийн халдварын шинжилгээнд хамрагдсан тоо	2109	2828	5176	8769	7800	8738

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Эрүүл мэндийн нэгдэл

1993 оны байдлаар 2109 жирэмсэн эх шинжилгээнд хамрагдаж байсан бол 2000 онд 2828 эх, 2004 онд 5176 эх, 2007 онд 8769 эх, 2013 онд 8738 эх болж өсөн нэмэгдсэн байна.

15-24 насны залуучуудын ХДХВ-ын урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамрагдсан байдал

Он	15-24 насны залуучуудын тоо	ХДХВ-ын шинжилгээнд хамрагдсан залуучуудын тоо	Дүнд эзлэх хувь
1993	40050	24030	60.0
2000	46000	32200	70.0
2005	42759	34209	80.0
2010	46377	8427	18.2
2013	47089	9819	20.9

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Эрүүл мэндийн нэгдэл

Сүүлийн жилүүдэд залуучууд эрүүл мэнддээ анхаарал тавьж, ХДХВ-ын урьдчилан сэргийлэх үзлэгт сайн дураараа хамрагддаг болсон байна. Түүнчлэн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг ХДХВ-ын үзлэгт нэгдсэн журмаар хамруулдаг болоод байна. 1993 онд 15-24 насны залуучуудын 60.0 хувийг ХДХВ-ын шинжилгээнд хамруулж байсан бол 2000 онд 70.0 хувь, 2005 онд 80.0 хувь болтлоо өссөн байна. Харин 2010 оноос хойш зөвхөн сайн дурын шинжилгээнд хамрагдаж байгаатай холбоотойгоор 20 хувь хүртэл буурсан байна.

Сүрьеэ өвчний тархалт Монгол улсын эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудлын нэг бол сүрьеэ өвчний тархалт бөгөөд тархалтаараа гуравдугаарт ордог халдварт өвчин юм. Сүрьеэ нь сүрьеэгийн *савханцар гэгдэх* нянгаар үүсдэг халдварт өвчин. Ихэнх тохиолдолд (70%) уушгийг гэмтээдэг ч бусад аль ч эрхтэнг гэмтээж болно.Энэ өвчнөөр хэн ч өвчилж болно. Учир нь ханиад томуутай ижил амьсгалын замаар халдварладаг юм. Сүрьеэгээр гэмтдэггүй эрхтэн гэж байдаггүй ч өвчилсөн хүмүүсийн ихэнх нь уушигны сүрьеэгээр өвчилдөг байна. Уушигны сүрьеэгээр өвчилсөн, цэрэнд нь сүрьеэгийн нян байгаа хүмүүс энэ өвчний халдварыг тараадаг байна. Тэдний ханиалгах, найтаах, цэрээ хаях, тэр байтугай ярих, дуулахад ч сүрьеэгийн нян агаарт цацагдан бохирдсон энэ агаараар нь амьсгалсан хүмүүс сүрьеэгийн халдвар авдаг. Гэхдээ энэ агаараар амьсгалсан хүн бүр халдвар авахгүй. Халдвартай сүрьеэтэй хүний гэр бүлийнхэн халдвар авч, биеийн эсэргүүцэл суларсан үедээ өвчлөх аюултай. Харин нийтийн унаа юмуу олон нийтийн газарт сүрьеэтэй хүн ханиалгаж байвал тэр хүнээс халдвар авах нь бага байдаг. Мөн сүрьеэгийн нян аяга таваг, өмссөн хувцас зэргээр дамжин халдварлахгүй. Сүрьеэ өвчнийг уушгины ба уушгины бус сүрьеэ гэж ангилна. Уушгины сүрьеэ 70%-ийг эзлэх бөгөөд дотор нь түрхэц эерэг, түрхэц сөрөг гэж хуваадаг. Дүүргийн хэмжээнд 100000 хүн тутмаас сүрьеэгээр өвчилсэн тохиолдол 2000 онд 57.39 промилл, 2005 онд 171.99 промилл болж өссөн бол 2010 оноос эхлэн буурах хандлагатай байна.

Сүрьеэ өвчний тархалт

Үзүүлэлт	2005	2010	2011	2012	2013
Сүрьеэгийн тархалт (100000 хүн амд)	171	115.7	116.9	116.2	110.6
Сүрьеэгийн нас баралт (100000 хүн амд)	9.7	6.3	4.2	6.3	5.4
ДОТС-ын хүрээнд халдвартай хэлбэрийн сүрьеэгийн илрүүлэлт хувиар	72.2	71.3	71.8	70.9	71.6
Шинэ халдвартай хэлбэрийн сүрьеэгийн эдгэрэлт хувиар	79.3	73.1	73.6	72.8	67.4

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Эрүүл мэндийн нэгдэл

Сүрьеэ өвчний улмаас нас барсан тохиолдол 100000 хүн тутамд 2000 онд 3.78 промилл байснаа 2005 онд 9.7 промилл болж өссөн бол 2010 онд 6.3 промилл, 2013 онд 5.4 промилл болж буурсан байна. Тус дүүрэгт сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж, эмчилсэн тохиолдол 2000 онд 90.5 хувь байсан бол 2007 онд 81.7 хувь, 2013 онд 71.6 хувь болж буурсан байна. Сүрьеэгийн эсрэг сайн эм байгаа хэдий ч сүрьеэ өвчний эсрэг тууштай тэмцэж чадахгүй байна. Иргэдийн буруу хэвшил болон үндсэн эмэнд дасал

болох явдал нь өвчлөл буурахгүй байх шалтгаан болж байна. Эмчлүүлээд эрүүл болсон хүмүүс олон түмний дунд сүрьеэ өвчний тухай таниулга хийж сүрьеэ өвчний шинж тэмдэг илэрвэл эмчид нэн даруй хандаж, хэрэв өвчилсөн бол эмчийн зааврыг дагаж эмчилгээгээ хийлгэвэл сүрьеэ өвчнийг ялж болно гэдгийг тэдэнд ойлгуулж, сурталчилж өгвөл өнөөдөр дэлхий даяар учирч буй гамшигийн нэг болоод байгаа сүрьеэгийн аюултай хийж байгаа тэмцэлд ихээхэн хувь нэмэр болох юм.

Хүүхдийн шүд цоорох өвчний тархалт Шүд цоорох өвчин гэдэг нь шүдний хатуу эдийн эрдэсийн алдагдлын улмаас шүдний хатуу эд зөөлөрч, шүдэнд хөндий үүсэх эмгэг процессийг хэлнэ. Дүүргийн хэмжээнд 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчин нь 2004 онд 92.9 хувь байсан бол 2007 онд 90.8 хувь, 2010 онд 80.0 хувь, 2013 онд 66.3 хувь болж буурсан байна.

Хүүхдийн шүд цоорох өвчний тархалт

Он	Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо	Өвчтэй гарсан хүүхэд	Өвчилсөн шүдний тоо	Шүд цоорох өвчний тархалтын хувь	Шүд цоорох өвчний эрчим
2005	2780	1345	6160	-	-
2006	4500	3560	7442	-	-
2007	4014	3346	19699	91.7	5.7
2008	1724	1345	7108	83.9	4.5
2009	6767	4983	22423	98.2	6.3
2010	3243	2815	12103	80	5.6
2011	2356	2034	8175	65.3	5.4
2012	2143	1901	7984	65.9	5.5
2013	2096	1823	7839	66.3	4.9

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Эрүүл мэндийн нэгдэл

Сүүлийн үед бага насны хүүхдийн шүд цооролт эрчимтэй ихсэж байна. Дөнгөж сүүн шүд цухуйвуу үгүй юу бүх шүд нь цооролд өртөж, хүмүүсийн ярьдагаар ёзоор үлдэж байна гэж их ярих болсон. Энэ нь хэдий хүүхдийн ерөнхий биеийн байдал муу, зарим эмийн хордлогын гаралтай үүсдэг тохиолдол байдаг авч ихэнхдээ эцэг, эх, халамжлагчийн буруугаас болдог. Хөхүүл хүүхдийг унтахад хөхийг аманд нь хийж унтуулах, өдөр тутам ундаа, шүүс зэргээр ундлах, хоол хооронд чихэрлэг хүнсний зүйл ихээр өгөх зэргээс болж бага насны хүүхдийн шүд их хэмжээгээр цоорч байна. Мөн бага насны хүүхдийг эцэг, эх, халамжлагч нь сойзоо дөнгөж барьдаг болонгуут нь шүдээ угаа гээд л хаячихдаг, оо сойзыг нь буруу сонгож өгдөг, хүүхдийн уурлаж зөрүүдлэхээс нь төвөгшөөж шүдийг нь гүйцэд угааж өгөлгүй орхих зэргээс болж дээрх байдал үүсдэг.



ЗОРИЛГО 7 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Зорилт 14. Тогтвортой хөгжлийн зарчмыг дүүргийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот суурингийн агаар цэвэршүүлэх

Зорилт 15. Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах

Зорилт 16. 2015 онд гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах

Зорилт 17. 2015 он гэхэд орон байрны нөхцөл муу хүмүүсийн аж байдлыг мэдэгдэхүйц дээшлүүлэх

Байгаль орчны тогтвортой байдал Сонгинохайрхан дүүрэг нь 120063 га талбай бүхий нутаг дэвсгэртэй. Дүүргийн нутаг дэвсгэрт орших Сонгинохайрхан уулын ноён оргил нь далайн түвшнээс дээш 1663 метрийн өндөрт өргөгдсөн байдаг бөгөөд хад асга ихтэй, хайлаас, харгана ургасан, агь, ганга, цагаан төмс, гандигар зэрэг эмийн ургамалууд ургадаг байна.

1998 оны байдлаар дүүргийн нутаг дэвсгэрийн ойн сан 20597 га байснаас 19550 га нь ойгоор бүрхэгдсэн байсан байна. Сүүлийн жилүүдийн хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан ойн сан бүхий газар нутгийн хэмжээ 2013 онд 21463.4 га болсон бөгөөд үүний 19548 га нь ойгоор бүрхэгдсэн байна. Ойн сангийн 68.0 хувийг хөгшин ой эзэлж байсан ба ойг цэвэрлэх ажлыг удаа дараалан зохион байгуулан хийж ирсэн.

Ойт нутгийн эзлэх хувь

Үзүүлэлт	1992	2000	2007	2013
Сонгинохайрхан дүүрэг	23.3	22.5	23.3	16.3

Мэдээллийн эх үүсвэр: Нийслэлийн статистикийн хэлтэс

Дүүргийн хэмжээнд ойгоор бүрхэгдсэн газрууд болох Баянхошууны зүүн баруун салаа, Байшинт уул, Хустайн ам, Жаргалантын нуруу зэрэг газраас иргэд хууль бусаар мод бэлтгэх болсон нь ойн санд муугаар нөлөөлөхийн зэрэгцээ ойн түймэр гарч багагүй хэсгийг шатаасан зэрэг нь ойг ихээр сүйтгэсэн байна.

Тусгай хамгаалалтад авсан газар нутаг Иргэдийн байгаль орчноо хамгаалах, ойг нөхөн сэргээх, түүхийн дурсгалт газруудыг хадгалан хамгаалах идэвхи санаачлагын дүнд Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 8 сарын 16-ны өдрийн 5\2 тоот тогтоолоор Байгалийн унаган төрх, байгаль орчныг бохирдуулах эх үүсвэрийн байршил, байгаль орчинд онцгой нөлөө үзүүлэх гол, голын эх, сав газрыг хамгаалах зорилгоор дүүргийн 20, 32 дугаар хорооны нутаг дэвсгэрийн “Сонгинохайрхан” уулын зүүн бэл, голын тохой орчим 650,5 га, Байгалийн унаган төрхтэй газрыг хамгаалах зорилгоор 21 дүгээр хорооны Бурхантын ам орчимын 484 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах шийдвэр гаргаж, тусгай хамгаалалтад авсан байна.

Агаарын бохирдол Агаарын бүтэц шинж чанар өөрчлөгдөхийг агаарын бохирдол гэдэг бөгөөд энэ хүний эрүүл мэнд, экосистемд / байгаль, хүн хооронд/ таагүй нөлөө үзүүлдэг. Агаарын бохирдолт байгалийн ба хүний гаралтай байж болно. Байгалийн гаралтай агаарын бохирдол нь байгалийн үйл явцаар үүсэх бөгөөд үүнд галт уул дэлбэрэх, уулын чулуулаг элэгдэх, ургамал хэт их цэцэглэх, /хөл газрын

ургамал- энгийн яриагаар хогийн ургамал гэж нэрлэдэг шарилж, лууль / ойн болон гал түймрийн утаа гэх мэт хамаарна.

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй агаарын бохирдол нь үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад янз бүрийн хорт бодис агаарт хаягдсанаас үүсдэг. Энэ нь цар хүрээгээрээ байгалийн гаралтай агаарын бохирдолыг давдаг. Агаар бохирдуулах эх үүсвэрүүд гэвэл: сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдаж байгаа хүн амын механик хөдөлгөөн ихэссэнээс гэр хороолол тэлж, хотын нягтрал нэмэгдсэн. Хот дотор шинээр баригдаж байгаа байшин барилгын хоорондын зай багасч, агаарын урсгалыг сааруулж, бохирдлын сарнилтыг саатуулж байгаа.

Улаанбаатар хотын агаарын үзүүлэлт

Үзүүлэлт	2010	2012	2013
Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн өвлийн хоногийн дундаж агууламж мкг\м ³	52.0	66.8	89.0
Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн өвлийн дундаж агууламж мкг\м ³	63.0	81.2	62.5
Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн давхар ислийн ялгаралт тонн\хүн	4.36	6.64	7.32

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ, Статистикийн эмхэтгэл 2013

Томоохон хотуудын хүн амын өвчлөлд суурьшил ахуйн орчны эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллийг судалж үзэхэд агаарын найрлага дахь нүүрстөрөгчийн дутуу исэл, хүхэрлэг хий, азотын давхар исэл, хөрсний бохирдолтоос үүсэх хар тугалга нь дагнасан буюу хавсарсан байдлаар нөлөөлж байгаа нь судалгаагаар тогтоогдсон байдаг. Улаанбаатар хотод амьсгалын замын өвчлөл өндөр байгаа нь хотын агаар дахь тоосны хэмжээ, хүхэрлэг хийн агууламжтай шууд хамааралтай байхад хөдөөгийн хүүхдийн амьсгалын эрхтний өвчлөл нь бохирдуулагчийн нөлөөтэй бус харин цаг уурын хүчин зүйлтэй хэт даарах, халууцах/илүү хамааралтай байгааг илрүүлжээ.

Агаар бохирдолтой байх нь амьсгалын зам, цусны эргэлтийн тогтолцоо, хавдар үүсэхэд нөлөөлдөг болох нь судалгаагаар батлагдсан билээ. Сүүлийн жилүүдэд манай улсын хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судас болон амьсгалын замын өвчлөл эхний байруудад орж байна сүүлийн 5 жилийн статистик үзүүлэлтээс / амьсгалын тогтолцооны өвчин 10.000 хүн амд 2007 онд 729,69 байсан 2010 онд 954.82 болж, 225.13-тохиолдлоор , ЦЭТ өвчлөл 2007 онд 563,23 байсан 2010 онд 648.06 болж, 84.83 – тохиолдолоор нэмэгдсэн гэсэн үзүүлэлтэй байна. Нөгөө талаар агаарыг бохирдуулагч бодисууд нь бие махбодийн өвөрмөц бус дархлалын урвалыг өвчилж гадны эмгэг төрөгч нянгуудыг эсэргүүцэх чадварыг сулруулж хүн амын өвчлөл ялангуяа арьсны болон харшилт өвчин үүсэх нөхцөл болж байна. 2007 онд -323,07 байсан 2010 оны

өвчлөлтэй харьцуулан үзэхэд 403.58 өвчлөл 80.51 нэмэгдсэн. ДЭМБ –ын мэдээгээр дэлхийд жил бүр 10сая хүн хорт хавдраар өвчилж, 7 сая хүн нас барж байна. Манай улсад 100.000 хүн амд ноогдох хорт хавдрын өвчлөл 2007 онд 128,95 байсан 2010 онд 160.63 болж, нас баралт 94,4- 105,18 болж өсч байна.

Нийслэл хотод агаарын бохирдол жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд төр, иргэд олон нийтийн зүгээс агаарын бохирдолыг бууруулах ажлыг зохион байгуулан явуулж байна. Агаарын бохирдолыг бууруулах ажлын хүрээнд дүүргийн ногоон бүсийг нэмэгдүүлэх явдал бөгөд жил бүр тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг хийхийн зэрэгцээ Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилгаар жилд хоёр удаа бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулан хийж ирсэн байна. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2001 онд шинээр 2470 ширхэг мод, 1120 сөөг тарьж суулгаж байсан бол 2010 онд 3788 мод, 6080 сөөг, 2013 онд 2200 мод, 500 сөөг шинээр суулгасан байна.

Шинээр тарьсан мод, сөөг

Үзүүлэлт	2001	2005	2010	2013
Шинээр тарьсан мод, ширхэг	2470	2846	3788	2200
Шинээр тарьсан сөөг, ширхэг	1120	8095	6080	500

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн ЗДТГ

Агаарын бохирдолыг нэмэгдүүлэх бас нэг эх үүсвэр нь автомашин гэж үздэг бөгөөд хүн амын амьжиргааны түвшин дээшлэх тутам автомашины хэрэглээ өсөн нэмэгдэж байна. Үүнтэй уялдуулан автомашинаас утааны татвар авдаг болсон бөгөөд хүн амын тоо өсөхийн хирээр автомашины тоо улам бүр өсөн нэмэгдэж байна.

Автомашины тоо

Он	Автомашины тоо- бүгд	Бүгдээс: төрлөөр				
		Суудлын	Ачааны	Автобус	Цистерн*	Тусгай зориулалтын
1998	6597	3923	1259	887	310	218
2000	7414	4348	1270	1292	309	195
2005	12693	8454	1930	1433	173	309
2010	29731	21059	6200	2031	-	264
2013	45198	32177	9564	2229	-	1228

Мэдээллийн эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газар

1998 онд дүүргийн хэмжээнд 6597 автомашин байсан бол 2000 онд 7414, 2005 онд 12693, 2010 онд 29731, 2013 онд 45198 болж өссөөр байна.

Хог хаягдал Монгол улсын хэмжээнд зөвшөөрөлтэй 426 төвлөрсөн хогийн цэг, нийт 11.798 мянган га талбайг хамарч байна. 2012 оны байдлаар жилд дунджаар 1.1 сая тонн хог хаягдал гарч байгаагаас 500-550 мянган тонн буюу тэн хагас нь Улаанбаатар хотоос гарчээ. Нийслэлд өдөрт 246 тонн, жилд 90 шахам мянган тонн хог хаягдал зөвшөөрөлгүй газарт хаягдаж байна.

Нийслэлийн Захирагчийн ажлын албаны тооцоолсноор Улаанбаатар хотоос өвлийн улиралд өдөрт дунджаар 1237.2 тонн хог хаягдал бий болдог. Үүнээс 145.7 тонн хог хаягдлыг орон сууцанд амьдарч буй айл өрхүүд “үйлдвэрлэдэг” бол гэр хорооллын айл өрхүүдээс 690.8 тонн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанаас 159.9 тонн хог хаягдал гардаг. Нарангийн энгэр, Улаан чулуут, Морингийн даваа, Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт өдөрт 2000-2500 тонн ахуйн хаягдлыг хүлээн авч ландфил технологиор дарж устгадаг.

Хог цэвэрлэгээ

Үзүүлэлт		2001	2005	2010	2013
Цэвэрлэсэн зам талбай	мян м ²	4406	4493	1351	540.9
Тээвэрлэсэн хог	мян.м ³	91.4	120.0	64.1	636.9
Дарж устгасан хог	мян.м ³	-	-	8.9	15.6

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн ЗДТГ

Дүүргийн 32 хорооны нутаг дэвсгэрт гурван тохижилт үйлчилгээний байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт хог тээврийн 50 машин үйлчилдэг байна. 1993 онд тохижилт үйлчилгээний нэг байгууллага 10 машин үйлчилдэг байсан бөгөөд 2000 онд 15 машин, 2005 онд 22 машин болж нэмэгдсэн байна. 2001 онд 91.4 мян.м. куб хог тээвэрлэж байсан бол 2005 онд 120.0 мян.м.куб, 2013 онд 636.9 мян.м.куб хог тээвэрлэх болсон байна. Хог хаягдал, бохирдлыг гаргахгүйн тулд зайлуулах, боловсруулах, эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад гол нь биш эх үүсвэр дээр нь бууруулах менежмент хийх хэрэгтэй нь чухал. Аж ахуйн нэгж, үйлдвэрүүд хог хаягдлыг бууруулахын тулд хамгийн түрүүнд уламжлалт практикаа эргэн хянаж, стратеги төлөвлөгөө гаргах хэрэгтэй. Нийт ажилчиддаа юунд хүрэхийг зорьж буйг ойлгуулж, удирдлагын алсын харааг илэрхийлэх, тэднийг чиглүүлэх, үлгэр жишээ үзүүлэх, хэрэгцээт төсвийг хангах нь чухал ач холбогдолтой.

Ундны усны хангамж Нийслэл хотын цэвэр усны эх үүсвэрийг Туул голын сав газраас хангадаг. Улаанбаатар хотын хувьд дөрвөн эх үүсвэр байгаа. Нийслэлийн усан хангамжийг төвийн эх үүсвэрийн “А”, үйлдвэрийн районы эх үүсвэр буюу “Б”, мах комбинатын “В”, дэд эх үүсвэр “Г” станц хэмээн хуваадаг. Үндсэндээ Туул голын сав газрын дагуу байгаа 160-170 гүний худгаас усаа татаад нийслэлчүүдийн ундны, ахуйн, үйлдвэрийн, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны

иргэдийн хэрэгцээг хангаж байгаа юм. Мөн энэ уснаасаа бид зөөврийн худгаар дамжуулан гэр хорооллын иргэдийн усны хэрэгцээг хангадаг. Зарим гэр хорооллын дунд ганц нэг гүний худаг бий. Эдгээр гүний худаг нь төвлөрсөн шугам сүлжээгээр явахгүй байгаагаас бохирдох магадлал өндөр байгааг хэлэх хэрэгтэй. Туул голыг дагаад Яармагийн гүүр хүртэл жижигхэн цагаан байшингууд байдгийг иргэд сайн мэднэ. Эдгээр байшингууд бол хотын ундны усны эх үүсвэрүүд юм. 2013 оны байдлаар дүүргийн нийт өрхийн 72.8 хувь нь гэр хороололд оршин суудаг бөгөөд 1993 онд 13647 өрх зөөврийн ус хэрэглэж байсан бол 2000 онд 15900 өрх, 2005 онд 27300 өрх, 2013 онд 52241 өрх болж нэмэгдсээр байна.

Зөөврийн ус хэрэглэдэг өрхийн тоо

Үзүүлэлт	1993	2000	2005	2010	2013
Гэр хорооллын хүний тоо	51371	84145	131345	186940	208978
Ус түгээх цэгийн тоо	33	70	111	148	152
Зөөврийн ус хэрэглэдэг өрхийн тоо	13647	15900	27303	40912	52241

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Статистикийн хэлтэс

2005 оноос эхлэн Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах төслийн хүрээнд Баянхошуу бүс, Толгойт бүсийн зарим ус түгээх цэгүүд цэвэр усны шугамын сүлжээнд бүрэн холбогдсон байна. Хэдийгээр ус түгээх цэгийн тоо нэмэгдэж, цэвэр усны шугам сүлжээнд холбох ажлуудыг хийж байгаа боловч шинээр суурьшилийн бүсүүдэд ундны усны хүрэлцээ хангамж муу хэвээр байна.

Орон сууцны хангамж 2013 оны байдлаар дүүргийн нийт өрхийн 27.1 хувь нь нийтийн орон сууцанд амьдарч байна. Нийт өрхийн 31.1 хувь нь байшинд амьдарч байгаа бол монгол гэрт 35.1 хувь нь амьдарч байна. Сүүлийн жилүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт орон сууцны хороолол баригдаж байгаа хэдий ч иргэдийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. 2010 оны байдлаар орон гэргүй 228 өрхийн 664 хүн байсан бол 2013 оны байдлаар орон гэргүй 99 өрхийн 293 хүн байна.

Оршин суугчдын тоо, сууцны төрлөөр

Үзүүлэлт	2000"	2005	2010	2013
Нийтийн орон сууцанд оршин суугчдын тоо \ өрх\	12748	12518	16193	19426
Байшинд оршин суудаг өрхийн тоо		15286	21629	26593
Монгол гэрт амьдардаг өрхийн тоо	24570	13548	19283	25190

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Статистикийн хэлтэс

"- хүн ам, орон сууцны тооллогын дүн



ЗОРИЛГО 8 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Зорилт 18. Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх

Зорилт 19. Мэдээлэл, холбооны шинэ технологийг хөгжүүлэх, мэдээлэлжсэн нийгэм байгуулах

Эдийн засгийн хөгжил Эдийн засгийн гол салбар болох аж үйлдвэрийн салбарын хувьд нийслэлийн аж үйлдвэрийн томоохон төлөөлөл болох хүнсний үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна. Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 1993 онд 412.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 2000 онд 15963.1 сая төгрөг, 2005 онд 34651.6 сая төгрөг, 2013 156161.4 онд сая төгрөг болж өсөн нэмэгдсэн байна. 2013 онд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ 2005 оныхоос 4.5 дахин өссөн байна. Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэхийн зэрэгцээ хүнсний болон хүнсний бус үйлдвэрүүд шинээр нээгдсэн байна. Аж үйлдвэрийн салбарын хөгжилт нь дүүргийн эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж байгаа билээ. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг харвал 1993 онд 6760.9 сая төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт хийж байсан бол 2000 онд 15237.4 сая төгрөг, 2005 онд 33605.5 сая төгрөг, 2013 онд 163052.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт, сая төгрөг

Үзүүлэлт	Үйлдвэрлэлт			Борлуулалт		
	Бүгд	Хүнсний	Хүнсний бус	Бүгд	Хүнсний	Хүнсний бус
1993	412.9	321.4	91.5	6760.9	5742.5	1018.4
2000	15963.1	14673.5	1289.6	15237.4	14026.8	1210.6
2005	34651.6	32071.3	2580.3	33605.5	30995	2610.5
2010	129115.6	116633	12482.6	148353.7	135583.3	5940.4
2013	156161.4	144259.1	11902.3	163052.8	154210.9	8841.8

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Статистикийн хэлтэс

Түүнчлэн худалдаа, үйлчилгээний салбарын орлого 2000 онд 2066.4 сая төгрөг байсан бол 2005 онд 2767.4 сая төгрөг, 2010 онд 175474.8 сая төгрөг, 2013 онд 1053.9 тэрбум төгрөг болж өсөн нэмэгдэж байгаагаас харахад аж ахуйн нэгжүүдийн худалдаа, үйлчилгээний орлого нэмэгдэж байгаа хандлага байна.

Худалдааны орлого, сая төгрөг

Үзүүлэлт	2000	2005	2010	2011	2012	2013
Худалдааны орлого- бүгд	2066.4	2767.4	175474.8	742208.4	951724.4	1053947.6

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Статистикийн хэлтэс

Аж ахуйн нэгжийн тоо жил бүр өсөн нэмэгдэж байна. 2002 онд 2905 аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдэж байсан бол 2005 онд 4135, 2010 онд 7261, 2013 онд 11426 болсон байна. Хэдийгээр аж ахуйн нэгжийн тоо өсөн нэмэгдэж байгаа боловч шинээр бий болсон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа эхлүүлээгүй, хөрөнгө оруулалт санхүүжилтын асуудлаас шалтгаалан олон аж ахуйн нэгжүүд үйл

ажиллагаа явуулаагүй түр зогссон байна. 2010 оны байдлаар бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 65 орчим хувь, 2013 оны байдлаар 43.4 хувь нь ажил үйлчилгээ явуулж байна.

Аж ахуйн нэгжийн тоо

Үзүүлэлт	2002	2005	2010	2011	2012	2013
Аж ахуйн нэгж, байгууллагын тоо-бүгд	2905	4135	7261	8491	9795	11426

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Татварын хэлтэс

Мэдээлэл холбоо Мэдээлэл харилцааны технологи нь нийгмийн амьдралд хамгийн өргөн хэрэглэгдэж байна. Мэдээлэл харилцааны технологи бол хүмүүс хоорондоо харилцах, шийдвэр гаргах, асуудал шийдэх шинэ арга ухаан, өөрөөр хэлбэл дараах үйл ажиллагаанд зориулагдсан процесс, хэрэгсэл ба арга замууд юм. Үүнд:

- мэдээлэл цуглуулах ба таних
- мэдээлэл ангилах ба зохион байгуулах
- мэдээллийг нэгтгэн дүгнэх
- мэдээллийг задлан шинжлэх ба үнэлэн цэгнэх
- эргэцүүлэн бодох ба урьдчилан таамаглах
- боловсруулсан мэдээлэлд үндэслэн асуудал шийдэх, шийдвэр гаргах

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн өсөлттэй уялдан дүүргийн иргэд ч энэ салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнээс чөлөөтэй сонгон үйлчлүүлж байна. Сүүлийн жилүүдэд интернэт холбооны үйлчилгээ үзүүлдэг аж ахуй нэгжүүд нэмэгдэж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Мэдээлэл холбооны үзүүлэлт \ Улсын дундаж \

Үзүүлэлт	2010	2011	2013
Суурин утасны цэгийн тоо \1000 хүн тутамд\	52	47	73
Интернэт байнгын хэрэглэгчдийн тоо \1000 хүн тутамд\	73	164	263
Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо \1000 хүн тутамд\	925	1056	1465

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ, Статистикийн эмхэтгэл 2013

2005 оны байдлаар дүүргийн хэмжээнд нийт өрхийн 92.2 хувь нь телевизортой, 3.5 хувь нь компьютертэй байсан бол 2010 онд нийт өрхийн 96.9 хувь нь телевизортой, 19.5 хувь нь компьютертэй болсон бол 2013 онд нийт өрхийн 98.5 хувь нь телевизортой, 33.4 хувь компьютертэй болсон байна. Төрийн болон хувийн

хэвшлийн байгууллагууд интернэтийн үйлчилгээг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн бөгөөд гар утас хэрэглэдэггүй хүнгүй болсон байна.

СХД-ийн интернэт, компьютертэй өрхийн тоо

Үзүүлэлт	2005	2010	2013
Өрхийн тоо	44862	55928	71747
Компьютертэй өрхийн тоо	41366	54181	23976
Үүнээс: интернэтэд холбогдсон өрхийн тоо	1583	10912	11553

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Статистикийн хэлтэс

2010 оны байдлаар 11160 компьютертэй өрхийн 4028 буюу 36.1 хувь нь интернэтэд холбогдсон байна. 2013 оны байдлаар компьютертэй өрхийн тоо 23976 болсон ба интернэтэд холбогдсон өрхийн тоо 11553 болоод байгаа ба 2010 оныхоос 2.8 дахин өссөн байна.



ЗОРИЛГО 9 ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ

Зорилт 20. Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ

Төрийн байгууллага Төрөөс иргэдэд олон төрлийн үйлчилгээг үзүүлдэг. Төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх авах, ямар нэгэн үйл ажиллагаа эрхлэх төрөл бүрийн зөвшөөрлүүд гэх мэт. Төрийн үйлчилгээний хүнд суртал нь дараах шалтгаануудаас болж үүсдэг байна. Үүнд:

Үйлчлүүлэгч: талаас:

1. Тухайн үйлчилгээний талаарх мэдлэг хомс;
2. Тухайн үйлчилгээний талаар мэдээллийг дутуу цуглуулсан;
3. Тухайн үйлчилгээтэй холбоотой бүрдүүлэх шаардлагатай баримт бичгүүдийг үнэн зөв, бүрэн гүйцэт бүрдүүлэхээс залхуурдаг, дутуу хийдэг г.м.;

Үйлчлэгч: талаас:

1. Үйлчилгээний үйл явц /процесс/-ыг дутуу сэдэж зохион байгуулсан;
2. Үйлчилгээний талаарх хэрэгтэй мэдээллийг олон нийтэд дутуу хүргэдэг;
3. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор хэрэггүй зүйлийг үйлчлүүлэгч нараас шаарддаг;
4. Үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд нь үйлчилгээний ач холбогдлыг бүрэн гүйцэт ойлгоогүй;
5. Үйлчилгээний соёлыг байгууллагын төвшинд бүрэн хэвшүүлээгүй г.м.;

Төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй болгоход чиглэгдсэн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд иргэд дүүргийнхээ төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны үйл ажиллагааны үндсэн зорилгыг ойлгодог болж бүх шатны хуралд тэдний дуу хоолойг сонсож, санал дүгнэлтийг үйл ажиллагаандаа тусгадаг болоод байна.

Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүнд сурталгүй хүргэх үүднээс дүүргийн Засаг даргын тамгын газрын байранд иргэний танхим байгуулсан ба дүүргийн цахим хуудсаар иргэдийн санал мэдээллийг байнга шуурхай хүлээн авч шийдвэрлэдэг болсон байна.

Дүүргийн цахим хуудсанд байрлуулсан төрийн үйлчилгээнд өгсөн иргэдийн үнэлгээнээс харвал: 2014 оны 10 сарын 28-ний өдрийн байдлаар *Манай дүүргийн үйлчилгээ хангалттай байна уу* гэсэн асуултанд өгсөн үнэлгээг авав.

Нийт санал өгсөн хүмүүсийн 50.34 хувь нь маш хангалтгүй, 15.58 хувь нь хангалттай, 13.68 хувь нь хангалтгүй, 13.02 хувь нь маш хангалттай, 7.39 хувь нь дунд зэрэг гэсэн үнэлгээ өгсөн байна.

ДҮГНЭЛТ

НҮБ-ын Мянганы дээд хэмжээний уулзалтаар 2000 оны 9-р сард Мянганы тунхаглал бичгийг баталсан. Мянганы тунхаглалд нэгдсэн улсуудын нэгэн адил Монгол улсын Их хурал НҮБ-аас дэвшүүлсэн зорилтыг дэмжиж, ардчилсан засаглалыг бэхжүүлэх тухай зорилгыг нэмж тусган Монгол улсын Мянганы хөгжлийн 2015 он хүртэлх зорилтыг нийт 9 зорилго, 22 зорилт, 24 шалгуур үзүүлэлттэйгээр 2005 онд 25 дугаар тогтоолоор баталсан бөгөөд 2008 онд 13 дугаар тогтоолоор шинэчлэн нийт 9 зорилго 24 зорилт 67 шалгуур үзүүлэлттэй байхаар шинэчлэн баталсан.

Сонгинохайрхан дүүрэг нь Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхээр төсөл хэрэгжүүлсэн анхны дүүрэг юм. Төсөл хэрэгжих хугацаанд дүүргийн Мянганы хөгжлийн зорилтын тайлан илтгэлийн бичсэн бөгөөд төслийн хэрэгжилтийн хугацаанд дүүргийн Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийг тодорхойлон, дүүргийн хэмжээнд гарч болохуйц тоон үзүүлэлтүүд дээр үндэслэн хийгдсэн. Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийн нэг хэсэг нь дүүргийн түвшинд тооцож болохооргүй үзүүлэлтүүд бөгөөд тооцож болохуйц үзүүлэлтийн хувьд дүүргийн түвшинд хир байгааг харуулахыг зорилоо. Өнгөрсөн хугацаанд дүүргийн төр, захиргааны байгууллагуудын өмнөө тавьсан зорилго зорилтоо хэрхэн биелүүлж ирсэн нь энэхүү товч танилцуулгаас харагдах байх гэж найдаж байна. Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийн тавьсан зорилго нь өнөөгийн бидний үйл ажиллагааны үндсэн зорилго бөгөөд дүүргийн өмнө тулгамдаж буй асуудлуудыг дүүргийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусган оруулснаар дүүргээ хөгжүүлэх, иргэд нь эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох бүхий л нөхцөл боллоцоо бүрдэх юм.

Зорилго 1. Ядуурал бол нийгмийн үзэгдэл, эдийн засгийн категори юм. Нийгмийн үлэмж хэсэг нь ядуурлын түвшинд очвол нийгэм өөрөө тогтворгүй болж дайн бйалдаан, өвчин тахал, хувьсгал, анги хоорондын хямрал зэрэг нь нийгмийн хамарсан гэнэтийн ядуурлын цаад шалтгаан болдог байна. Ядуурал нь тухайн нийгмийг тогтворгүй болгож улам ядууруулах асуудлыг цаашлуулан хурдасгах шалтгаан болдог учраас макро эдийн засгийн тулгуур ойлголтын нэг юм. ҮСХ-ны зохион байгуулан явуулдаг үндэсний хэмжээний Өрхийн орлого зарлагын судалгааны үр дүнгээр ядуурлын түвшинг тооцон гаргадаг бөгөөд энэхүү үзүүлэлт дүүргийн түвшингээр гардаггүй болно. ҮСХ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хөгжүүлэх төслийн хүрээнд хүн амын тооллогын тоо, мэдээлэлд суурилсан ядуурлын зураглалыг дүүргээр гаргасан байдаг. Энэ судалгааны дүнгээр 2003 онд дүүргийн хэмжээнд

ядуурлын хамралтын хүрээ 0.317, ядуурлын гүнзгийрэлтийн индекс 0.087 байсан ба 159346 хүнээс тооцож гарсан ядуу хүн амын тоо 50513 байсан байна. Үүнээс өмнө дүүргийн хэмжээнд ядуу өрх, хүн амыг тооцож байсан бөгөөд энэхүү тооцоо нь учир дутагдалтай байсан тул ҮСХ-с тооцох болсон. Гэхдээ дүүргээр гарсан тоо мэдээлэл хангалтгүй, арга аргачлалыг шинэчлэх шаардлагатай байна.

Зорилго 2. Боловсролын тоо мэдээлэл нь захиргааны мэдээлэлд багтдаг бөгөөд БСШЯ-д төвлөрүүлэн авдаг. Энэхүү судалгаанд бид дүүргийн боловсролын хэлтэсээс тоо мэдээллийг авч ашигласан бөгөөд сүүлийн жилүүдэд боловсролын салбарын тоо мэдээлэл харьцангуй сайжирч байгаа боловч дүүргийн түвшинд зарим нэг үзүүлэлтийг тооцоход учир дутагдалтай байна. Хамран сургалтын цэвэр жин, сургууль завсардалт зэрэг үзүүлэлтүүд тодотгох шаардлагатай байна. Түүнчлэн сургууль, цэцэрлэгийн тоо хэмжээ нэмэгдүүлэхээс гадна чанарыг сайжруулах, анги дүүргэлтийг аль болох багасгах багш нарын ачаалалыг багасгах зэрэг боловсролын салбарын өмнө тулгамдсан асуудлууд их байгаа бөгөөд эдгээр асуудлуудыг дан ганц дүүрэг бие дааж шийдвэрлэх боломжгүй юм.

Зорилго 3. Жэндэрийн талаарх тоо мэдээлэл хомс бөгөөд бага дунд шатны боловсрол эзэмшигчдийн хүйсийн харьцаа дүүргээр гарах боломжтой байна. Бусад үзүүлэлтүүд дүүргээр гаргахад бэрхшээлтэй байна.

Зорилго 4-6. Энэ зорилтын үзүүлэлтүүд эрүүл мэндийн салбарын тоо мэдээлэлээр гаргасан бөгөөд харьцангуй тоо мэдээлэл нь дүүргийн түвшинд бүрэн гарч байгаа үзүүлэлтүүд юм. Энэхүү танилцуулгад ашигласан эрүүл мэндийн тоо, мэдээлэлийг дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлээс авсан бөгөөд эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, эмч нарын ачаалалыг багасгах, өрхийн эмнэлэгүүдийн үйл ажиллагааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх зэрэг нь иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний салшгүй нэг хэсэг болно. Эрүүл мэндийн байгууллагуудын үйлчилгээ сайжирснаас хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтүүд дээшлэх боломжтой бөгөөд хамгийн олон хүн амтай, алслагдмал дүүргийн хувьд төрөх эмнэлэгтэй болох хэрэгцээ шаардлага байна.

Нийгэм байнга өөрчлөгдөж байдаг тул үүнийг дагаад өвчин, эмгэг, осолд хүргэж буй нийгмийн шалтгаанууд өөрчлөгддөг. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг баталсан байна. Энэхүү баримт бичигт:

1.1 Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилго нь байгаль, хүн, нийгмийн зохицлыг хангаснаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах таатай нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

1.2. Нийгмийн эрүүл мэндийг төлөвшүүлэх гэж хүний амьдралын чанарын түвшинд сөргөөр нөлөөлж, өвчин, эмгэг, осол, гэмтэлд хүргэж буй нийгэм, эдийн засаг, орчны хүчин зүйлээс сэргийлэх, шалтгаан, үр дагаврыг арилгах, хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нийгмийн нөөц, бололцоог зүй зохистой ашиглах үйл ажиллагааг хэлнэ.

1.3. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг зөвхөн өвчин эмгэгийг эрт илрүүлэх, төгс эмчлэх төдийгүй, эрүүл хүнд хандуулах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх нь хүний хөгжлийн чухал хэсэг болох нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл болно, гэж заасан нь мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал заалт болж байна.

Зорилго 8. Тогтвортой хөгжлийн нэг гол асуудал болох эдийн засгийн өсөлтийг хангах, явдал бөгөөд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, тэднийг дэмжих үйл ажиллагааг төрийн зүгээс явуулах шаардлагатай бөгөөд эдийн засгийн хөгжлийг даган хүн ам ажил, орлоготой болно. Ажилгүйдлийн маш олон шалтгаан байдаг бөгөөд манай улсад өнгөрсөн болон өнөө үед их бага хэмжээгээр бодитой оршин байсаар байна. Ажилгүйдэлтэй холбоотой нийгмийн сөрөг үр дагавар болох орлого буурч ядуурал нэмэгдэх, гэр бүл сарних, хүн амын эрүүл мэнд муудах, боловсролын түвшин буурах, сэтгэл санааны гутранги байдалд орж гэмт хэрэг нэмэгдэх зэрэг үзэгдэлүүд улам бүр нэмэгдсээр байна. Олон хүний хувьд хөдөлмөрийн харилцаа нь орлогын эх үүсвэр бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд нийцүүлэн ажил олгогч, мэргэжлийн түр сургалтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласнаар ажилгүй иргэдийг ажил олгогчоос ирүүлсэн ажлын байранд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулах, жижиг зээл олгосноор ажлын байр шинээр бий болгох, нийтийг хамарсан буюу ногоон ажил зохион байгуулж ажилгүй иргэдийг түр ба байнгын, улирлын ажлын байраар хангах, нэг жилээс дээш хугацаагаар бүртгэлтэй байсан ажилгүй иргэд, зорилтот бүлгийн иргэдийг ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих зэрэг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйлчилгээ, арга хэмжээг төсөл хөтөлбөрүүдийн хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Тогтвортой хөгжлийн асуудлын хүрээнд тавигдах нэг гол асуудал экологийн бохирдол бөгөөд экологийн бохирдолтод нөлөөлж байгаа хэд хэдэн хүчин зүйл бий. Мэдээж байгаль цаг уурын дулаарал ихээхэн нөлөөлж байгаа нь дамжиггүй. Гэхдээ хамгийн гол хүчин зүйл бол хүний буруутай үйл ажиллагаа юм. Сүүлийн таван жил дараалан Туул гол хаврын хаварт тасардаг болсон. Ингэж тасрах болсон нь голын эхэнд байдаг Мөнгөн морьтын амнаас их хэмжээгээр мод бэлтгэснээс

болсон. Ой мод, ус хоёр харилцан уялдаатай, байгалийн шүтэлцээтэй зүйл. Мод гэдэг бол усны нөөцийг барьж байдаг чухал байгалийн баялаг. Гэтэл модыг их хэмжээгээр хяргаснаас болоод усны нөөц дундарч, Туул голын ус татарч бүр тасрахдаа тулаад байна. Энэ бол төр засгийн буруутай үйл ажиллагаатай холбоотой. Голын загас их хэмжээгээр үхлээ гэж ярьж байна. Гэтэл гол дотор голын усыг цэвэршүүлж байдаг асар олон төрлийн бичил биетэн байдаг. Тэдгээр бичил биетнүүд цөм үхэж, устаж байгааг ерөөсөө ярихгүй байна. Урсгал усанд бузар байхгүй гэж ахмад буурлууд маань ярьдаг байсан. Энэ үг үүнтэй холбоотой. Эдгээр бичил биетнүүд үхэх юм бол “гол үхлээ” л гэсэн үг. Энэ бол их том аюулын дохио.

Нийслэлийн усны нийт нөөц бол 230 мянган м/куб гэж 1977 онд оросууд тогтоож өгсөн байдаг юм байна. Үүний дараа Улаанбаатар хотын усан хангамжийн асуудлаар Жайка бас судалгаа хийсэн. Гэхдээ бас л нэг 230 мянган м/куб орчимд байна л гэсэн тойм зүйл гаргасан. Гэтэл 1977 оноос хойш өчнөөн жил хэрэглэсэн. Нийслэлийн хүн ам өсч, хэрэглээ асар их нэмэгдэж байгаа. Хотын хэрэгцээг 1 сая 200 мянган хүнээр бодоод тооцоход 328 мянган м/куб болж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр өдөрт 170 мянган м/куб усыг ундны усны эх үүсвэрээс авч төвлөрсөн сүлжээгээр дамжуулан хэрэглэж байна.

Зорилго 9. Төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа сайжрах тусам иргэд бидний хүртэх үйлчилгээ сайжирна. Иймд төрийн байгууллагууд хамтын ажиллагаанд арай өөр өнцгөөс харж хамтын үйл ажиллагаа сайжруулах, өргөжүүлнэ гэж найдаж байна.

Эцэст нь өнөөдөр бид үйлчилгээний соёлыг сайжруулахыг зөвхөн төрийн байгууллагаас шаардах нь зохимжгүй. Өөрсдөө хүнтэй боловсон харьцах, шаардлагатай баримт бичгүүдийг үнэн зөв боловсруулах зэрэг хичээх шаардлагатай. Хоёр талын зүтгэлээр л үйлчилгээний соелын стандарт дээшилнэ гэдэгт надтай хүмүүс санал нийлэх болов уу?

Ашигласан материал

- Монгол улсын статистикийн эмхэтгэл 2005-2013
- Сонгинохайрхан дүүргийн Статистикийн эмхэтгэл 1993-2013
- Сонгинохайрхан дүүргийн Статистикийн бюллетень 2008-2013
- Сонгинохайрхан дүүргийн Эдийн засаг, нийгмийн байдлын танилцуулга 2003-2013
- Сонгинохайрхан дүүргийн МХЗ-ын анхны илтгэл 2008 он
- Сонгинохайрхан дүүргийн ЭМН-ийн статистик мэдээ
- Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн мэдээлэл
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цахим хуудас
- Нийслэлийн Статистикийн газрын цахим хуудас
- Нийслэлийн Боловсролын газрын цахим хуудас
- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын цахим хуудас
- Сонгинохайрхан дүүргийн цахим хуудас
- ЕБ-ын 12 жилийн сургуулийн шилжилтийн 7-р ангийн сургалтын хөтөлбөрийн зөвлөмж
- Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төвийн цахим хуудас
- Улсын Их Хурлын 2001 оны 81 дүгээр тогтоолын хавсралт
- Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн цахим хуудам
- Хөдөлмөрийн яамны цахим хуудас
- Эрх зүйн туслалцааны төвийн цахим хуудас
- www.Baabar.mn